



ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СҮМҮН СОНГУУЛИЙН ХОРООНД

ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024. 08. 07 № 275  
танай -ны № -т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эзлжит сонгуульд оролцох ШИНЭ намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны эзлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны эзлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 – 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 – 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай

хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

ШИНЭ намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр ..... хуудсыг хавсаргав.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРМАНДАХ



## “ШИНЭ СОНГОЛТ-ШИНЭ МОНГОЛ”

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ийн  
хурлын сонгуулийн  
мөрийн хөтөлбөр - 2024

/ ОРХОН АЙМАГ /



Улаанбаатар хот 2024 он





## Жаргалант сум

1. Эрчимжсэн МАА, малын тэжээлийн үйлдвэрлэл хосолсон нэгдсэн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж буй иргэд, аж ахуйн нэгжийг дэмжинэ.
2. Зах зээлд өндөр үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүнийг нийлүүлэх хүлэмжийн аж ахуй болон бусад ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжинэ
3. Тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулаж, голлох нэр төрлийн тарималаар Орхон аймаг төдий ойролцоо аймаг, хотын хэрэгцээнд нийлүүлэх, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэгэдүүлэхийн төлөө аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шил ажиллагааг дэмжин ажиллана.
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлэх сургалт дадлыг эзэмшүүлэх, жижиг, дунд бизнес эрхлэлтийг дэмжиж ажиллана.
5. Ногоон байгууламжтай, амьдрах таатай нөхцөл бурдүүлэх, гудамж талбайг цэцэгжүүлэх ажлыг хувийн хэвшлийн байгууллагуудыг дэмжин ажиллана.

